

**ЧАНЧУНЬ БОМБЫГ УРЬСАН ЧИНГИС ХААНЫ ЗАЛЛАГЫН
ЗАХИДАЛ, ТҮҮНИЙГ ТОЙРСОН ЗАРИМ АСУУДАЛ**

Я.Ганбаатар¹

Сүүлийн үед Чингис хаанаас Чанчунь бомбыг урьж уулзсан түүхэн үйл явдлыг жирийн хүмүүс төдийгүй, улс төр, гадаад харилцааны хүрээнд ч анхааран судалж, холбогдох түүх бичлэг, ном судрыг дахин хэвлэх явдал идэвхжиж байна. Учир нь энэ бол яах аргагүй тухайн үеийн дэлхий дахины, олон улсын томоохон чухал үйл явдал, улс хоорондын харилцааны нэн сонирхолтой үйл хэрэг байсан юм. Тиймээс ч БНХАУ-ын дарга Ху Жинтао эл түүхэн үйл явдлыг дэлхий дахинаа энх тайвныг сэргээн тогтоож, улс хоорондын харилцаанд амар амгаланг эрхэм болгосон бодит алхмын түүхэн үлгэр жишээ хэмээн онцлон тэмдэглэжээ.

Монголчууд бид энэ үйл явдлыг бичиг нэлээд гадарлах боловч гүйцэд сайн мэдэхгүй, гүнзгий судлаагүй байна. Тухайн цаг үед буюу 13 дугаар зууны үед Монголыг, дэлхийн эзэнт гүрэн байгуулсан монголчуудыг сонирхон судлах, таньж мэдэх гэсэн сонирхол эрмэлзэл, зайлшгүй шаардлага хүчтэй тавигдаж болж, өрнө дорнын олон улс түмнээс элч болон жуулчлан ирж асан олон хүмүүсийн түүх бичлэгт тэмдэглэгдэн үлдсэн үйл явдлуудын дунд Чанчунь бомбын аялал жуулчлал онцгой байр эзэлдэг.

Тэгвэл энэ үйл явдлыг хамгийн товчоор хэдэн зүйлээр тодорхойлон дурдахад:

Нэгдүгээрт, Чингис хаантай уулзахаар Монгол хийгээд Дундад Азийн орнуудаар аялан жуулчилсан Чанчунь бомбын эл хэрэг явдал бол өрнөдийн Марко Поло, Плано Карпини, Гильом де Рубрук, хятадын Пэн Даяа, Сюй Гин зэрэг олон нэрд гарсан аялагч жуулчдын аялал жуулчлалаас хамаагүй өмнө буюу ямарч гэсэн эдгээр нэр бүхий аялагчдаас хамгийн түрүүнд болсноороо түүхэн үнэ цэн, ач холбогдлоороо зүйрлэшгүй юм.

Хоёрдугаарт, Чанчунь бомбо нь Монголын хэмээх тодотголтой дэлхийн эзэнт гүрнийг үндэслэгч агуу их Чингис хаантай биечлэн уулзаж, дэлхийн хэрэг явдал, төрийн боллого үйлийг хэлэлцэн зөвлөж явснаараа бусад нэр бүхий аялагч жуулчдад гохиогоогүй түүхэн их хувь заяаны эзэн болсноороо бас онцгой үйл явдал болсон юм.

Гуравдугаарт, Чингис хаанаас Чанчунь бомбыг урьж залсан заллагын захидал бол бодитой түүхэн баримт бичиг мөн бөгөөд үүгээрээ Чингис хааны үзэл бодол, үйл хэргийг хамгийн ихээр тусган үлдээсэн чухал ач холбогдол бүхий түүхэн бичиг баримт мөн. Өнөөдөр

¹. Монгол Улсын Гадаад Харилцааны Яам

Я.Ганбаатар

уг захидлын эх бичиг байхгүй ч түүнээс шууд хуулбарлан чулуун дээр сийлэн бичсэн хувь хадгалагдан өнөөг хүрч ирсний дээр Бээжин хотын Бай юнгуань хэмээх Чанчунь бомбын сүм зэрэг газарт түүнээс авсан хувь хуулбар, мөн уг захидлын дундад зууны үеийн худам монгол орчуулга зэрэг баримт бичиг судалгааны чухал эх сурвалж, судлагдахуун болж байна.

Одоо уг захидлыг хятад эх, монгол орчуулгаар нь үзэцгээе:

天 中原 太 之性。朕居北野嗜欲莫生之情。反朴 淳，去奢从，一衣一食，与牛 困共
弊同。民如赤子，士若弟兄，素和，思素畜，万 以身人之先，百 无念我之后，七
之中成大，六合之内 一。非朕之行有德，盖金之政无恒，是以受之天佑，承至尊。南
蛮宋，北接回，夏西夷，悉称臣佐。念我 于国千 百世已来，未之有也。然而任大守重，
治平犹惧有缺，且夫割舟 楫，将欲 江河也；聘 佐，将以安天下也。朕践祚以来，勤心庶
政，而三九之位未 其人。丘 先生，体真履，博物洽，探 理，道充德著，古君子之
夙，抱真上人之雅操。久栖岩谷，藏身 行。祖 之化，坐致有道之士，云集仙径，莫可
称数。自干戈而后，伏知先生犹 山 旧境，朕心仰 无已。不 渭水同、茅 三之事？奈
何山川弦，有失躬迎 之礼。朕但避位 身，戒沐浴，差近侍官 仲禄，素，不 数千
里，邀先生 屈仙，不以沙漠悠 念。或以 民当世之，或以恤朕保身之，朕 侍仙座，
惟先生将咳唾之余，但授一言，斯可矣。今者，聊 朕之微意万一，明于 章，望先生既着
大道之端，要善无不，亦 生小愿哉！故咨 示，惟宜知悉。

御宝五月初一日

至大二年四月朔

州石堂山石匠李 忠刊。

Эл захидлын монгол орчуулга нь дараах мэт болой:

“Мөнх тэнгэр, хятад иргэдийн хэтэрхий дээрэнгүй, омог бардмыг жигшсэн байнам. Хаан миний бие умар зүгийн Их хээр талд аж төрөн сууж, чин сэтгэлээр чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, сүйтгэн бүрэлгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоон адуучин үхэрчинтэй хуваалцан, ард иргэдийг үр хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эв эеийг эрхэмлэн, энэрэл хишгийг түгээмүй.

Түмэн олныг дайчлах их үйлд тэргүүлэн явж, олон их лайн тулаанд амь насаа умартан зүтгэсээр, долоон жилийн дотор төр улсын их үйлсийг бүтээвэй. Өдгөө би дөрвөн зүг найман зовхисын таван өнгө, дөрвөн харийн олон улс орныг нэгтгэн хураагаад нэгэн төрийн жолоонд орууллаа.

Гэвч энэ бол мөхөс миний үйл эрдэм ихийн тул бүтсэн хэрэг биш болой. Харин Алтан улсын төр засаг итгэлгүй тогтворгүй болоход Мөнх тэнгэрээс намайг ивээн тэтгэж, эрхэм дээдийг залгамжлан эдлэх хувь тохиол оноосны учир би бээр өмнө зүгийн Сүн төр улстай холбоо тогтоож, өрнө зүгийн Сартуул улстай хаяа нийлэх болсон агаад Зүүн Ся улс зэрэг харь этгээдийн олон улс орон надад харьяат түшмэл улс болон дагаад байнам. Сэтгэхүл энэ нь манай Шаньюйн улсад мянган он, зуун үед эс гарсан хэрэг болвой.

Хэдий тийм боловч надад оногдсон үйлс агуу, үүрэг хүнд учраас тэр бүхнийг тэгшлэн засахуйд алдас гаргахаас нэн ч сэргийлэн хичээнгүйлнэм. Завь онгоц үйлдэж залуур сэлүүрийг

Я.Ганбаатар

урлах нь гол мөрнийг гатлахын төлөө билээ. Өдгөө миний бие эрдэмтэн мэргэдийг залж, авьяастан чадвартныг түшихийг хүсч буй нь дэлхий дахиныг амарлиулахын төлөө болой. Гэвч миний бие хаан сууринд суусан цагаас янагш чин сэтгэлээр төр засагт зүтгэсээр өнөөг хүрэхдээ гурван гүн, есөн чингийн орноо үүнд нийцэх хүнийг хараахан эс олсон анам.

Харин өдгөө сонсохул Цю багштан Та бомбын үнэн биеийг олоод ёсыг журамлан ихийг үзэж, үлэмжийг мэдэн, далдыг ухаад, ёс зүйд нэвтрэн, эрдэм чадал төгс бүрджээ хэмээн улс даяараан алдаршиж, эртний богд мэргэдийн номлол сургаалыг өвөрлөн, эрдэмт хүмүний сайн ёсоор аглаг уулнаа бясалгал хийн удтал сууж буй гэнэм. Өвөг дээдсийнхээ үлдээсэн эрдэм увьдсыг өвлөн уламжилж, үнэнхүү эрдэмт арш болсон эрхэм Таныг, бомбын ёсны замд орсон сүсэгтэн олон үүлэн мэт хуран хүрээлсэн гэдгийг мөхөс би тугаархан олж мэдэвэй.

Хаан миний бие алсын аянд мордсон хойноо сая, эрхэм Таныг Шаньдунгийн хязгаар нугагтаан буйг сонсоод Таныг ихэд бишрэн санагалзах сэтгэл минь ер үл дарагдах болов. Бас Таны Вэйшуй голын хөвөөнөө сүйх тэргээр зорчсон хийгээд улалжин гэрт гурвантаа очсон зэрэг үлгэр домог болсон яриа хөөрөөг тань сонсон нэн ихээр бахархах боловч уул гол хэтэрхий алс хол тул энэ удаад биеэр хүрч учран золгож эс чадавай.

Иймийн тул мөхөс би алс газраас боловч суудлаасаан босч бие мэхүйн Танд ёсолж, шадар түшмэл Лю Жунлу-д хөнгөн улаа, сүйх тэрэг өгч илгээн, Таныг мянган газрын чанадаас урин залж байнам. Эрхэм арш биеийг түр зүдээн, элсэн цөлийг элчилгүй алс хэмээн төвөгшөөж буцалгүйгээр морилон ирж, түмэн олны зовлин зүдгийг арилгаж, дэлхий дахиныг засах үйл эрдмийг мөхөс надад зөвлөн хэлж, жич бас миний биед насыг уртасгаж, өлзий хутгийг бататгах увьдас эрдмийг зааж хайрлах болов уу.

Тэр цагт мөхөс би багш Таныг өөрийн биеэр хүндлэн асрангаа мэргэн үл шидэт сургаалыг тань сонсоё хэмээн ихэд хичээнгүйлэн хүснэм. Эрхэм Таны эрдэм сургаалыг түр ч атугай хүртвээс буян завшаан болох буй заа хэмээсэн үүгээр миний бие бодол сэтгэлийнхээ өчүүхэн төдийг цухас илэрхийлэн зарлигийн захидалд дурдавай. Эрхэм Та үүнээс хойчийн их үйлийн утга учрыг ойлгож ухсан бол Бомбын ёсыг гэрэлтүүлэн янагш морилон ирж, сайн явдлаас үл ухран, хамаг аьтны хүсэл сэтгэлийг эс чилээх болтугай.

Үүнийг тодорхой мэдэгдмүй. Лавтайяа сайтар хянан ухах буй заа.

Таван сарын шинийн нэгнээ бичиглэвэй.”

Энэ түүхэн чухал ач холбогдол бүхий захидлыг бичиг сударт янз бүрээр нэрлэж иржээ. Чингис хааны жуух бичиг, урилгын захидал, заллагын захидал, зарлигийн захидал гэж олон янзаар орчуулан оноож ирсэн энэ үгс хятадаараа бол “жаошу” буюу жуух бичиг гэсэн үгээр илэхийлэгдсээр иржээ. Олон хүн энэ захидлыг Чанчунь бомбыг дагалдан явсан түүний гарын шавь Ли Жичаны бичсэн “Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл”-д байдаг гэж ойлгодог. Гэвч тийм биш юм.

Юуны өмнө Ли Жичаны бичсэн “Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл”-ийн талаар эхлэн дурдая. Өөрийн хятад дайфу буюу хувийн эмч Лю Жунлу хэмээгчээсээ Хятад газар гурван зуун нас насалсан Чанчунь хэмээх гайхамшигт хүн - Бомбын ёсны их арш байдаг тухай сонссон хаан бээр түүнийг урин залж, учран уулзахыг ихэд хүсчээ. Үүнд хоёр шалтгаан буй. Нэг нь хаантан бээр ихийг үзэж, эрдмийн оргилд хүрсэн их мэргэд өтгөсийг дэргэдээ

Я.Ганбаатар

цуглуулж, дэлхийн дайдыг хураасан их улс гүрнийхээ төрийг хэрхэн засч, түмнийг хэрхэн жолоодох тухай ном ёсыг сонсох гэсэн хэрэг. Нөгөө нь насан өндөр болж асан хаантан өөрөө урт насалж, удаан жаргах далдхан хүсэлдээ хөтлөгдөн, биенийг сувилан тэтгэх арга ухааныг битүүдээн эрэлхийлж байсны учир болой.

Тэр ч ёсоор Чингис хаан насныхаа сүүл рүү олон улс оронд сонсогдсон эрдэмт мэргэдийг урьж залан, захидал бичиг илгээн харилцах болжээ. Хааны энэ чин хүслийг олж мэдсэн шадар дэргэдийнх нь хүмүүс, түүний дотор мөнөөх Лю Жунлу хэмээх нангиад оточ дайфу тодорхой учир шалтгааны улмаас хаанд ийнхүү худал дэгс зүйл дуулгасан байдаг. Чухам яагаад тэрбээр чингэж хэлэв? гэхүл магад, хаантанд улам их тал засч, хайр энэрэлийг нь олох гэсэн, бас өөрийн амь насыг аварч хоохойлох гэсэн арга ядсан арга чарга ч байсан байж болох талтай. Гэхдээ ямарч байсан Чанчунь бомбо бол хол ойрд нэр алдар нь түгсэн цуутай, номтой эрдэмт мэргэн арш байсан нь үнэн юм.

Ингээд Чанчунь бомбын тухай олж сонссон Чингис хаан, ямар ч байсан түүнтэй уулзахыг хүсчээ. Эхний удаа урихад Чанчунь бомбоос хариу ирээгүй тул шадар сайд Елүй Чуцайд үүрэг өгч эвтэй зөөлөн үйтэй заллагын захидлыг бичүүлж, өөрийн биеэр үзэн шалгаад элчид өгч илгээсэн байдаг. Түүнийг олон газрын хаад, ноёд урин залж, сургаал номлолоо айлдахыг хүсч байсан ч тэрбээр энэ үеийг хүртэл хэний ч хүсэлтийг биелүүлээгүй байжээ. 1219 оны билгийн улирлын тавдугаар сарын 19-ний өдөр бичсэн эл захидлыг дээр бид үзсэн билээ.

Түүнийг нь үзсэн Чанчунь бомбо энэ удаад цааргалан хойш сууж төвдсөнгүй, олон шавь нартаа: “-Тэнгэрийн цаг ирсэн болой. Би явах ёстой” хэмээн хэлээд дал шүргэж асан өндөр нас, өтөл биеэ үл хайрлан алсын их аян замд шуудран гарсан гэдэг. Чингэхгүй бол ч болохгүй байлаа. Дэлхийг эзэгнэсэн их хааны зарлиг тушаалыг хүлээн авч ёсчлон биелүүлэхгүй аваас түүнд, түүний улс орон, ард түмэнд улам их гай барцад, бэрх зовлон ирэх байсан байж магад. Энэ тухай ч Чанчунь бомбо шавь нартаа битүү утгаар хэлсэн байдаг. Ийнхүү 1219 оны дугаар сард Бээжингээс цааш орших Шаньдун нутгийн гүнээс эхэлсэн энэ түүхт аялал Хойд Хятад, Монгол орон, Дундад Азийн олон газар орноор ламжин бүтэн гурван жил үргэлжилж, 1223 оны хавар Бээжинд буцаж ирснээр өндөрлөсөн энэ аялалд багшийгаа дагалдан хамт явсан шавь Ли Жичан гэгч нь аяллын туршид бичиж тэмдэглэж явсан бүхнээ хожим нь эмхэтгэн нэгтгэж, энэхүү “Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх бүтээл мэндэлсэн болой. Энэ номыг 1997 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан Н.Ариунгуа эрдэм шинжилгээний орчуулга хийн анх монгол уншигчдын хүртээл болгосон бол миний бие өөрийн шавь Ц.Ганбаатар агсны хамтаар эрдэмтэн судлаач хийгээд нийт уншигчдад зориулан орчуулж 2010 онд хэвлүүлсэн билээ.

Одоо уг захидал руугаа эргэж орьё. Захидлын эх өнөөдөр хаа ч байхгүй, үрэгдэж үгүй болсон агаад золоор буянтай хүмүүсийн ачаар хуулбарлагдан өнөөг хүрч иржээ. Захидлыг хаанаас олсон бэ? гэхүл ийм түүхтэй ажгуу. 1309 онд Хэнань мужийн Нэйсян хошууны Шитан шань хэмээх ууланд агч Пузи гун хэмээх сүмийнхэн Чингис хааны алдар сууг мөнхөлж, Чанчунь бомбын байгуулсан гавьяаг алдаршуулах зарилгоор Дэнжоу нутгийн чулуучин Ли Зинжун гэгчээр чулуун дээр сийлүүлэн бичүүлж үлдээжээ. Тухайн үед зарлигийн захидлыг олшруулан хувилж, Бомбын шашны сүм хийдүүдэд тараан түгээж байж гэж үзэхэд хүргэлэг. Уг хөшөө чулуу нь 1.8 м өндөр, 63 см өргөн, 23 см зузаантай агаад хятад ханз үсгийн хичээнгүй бичгийн тигээр сийлэн бичсэн, нийт 16 мөр, нэг мөрөндөө 32 ханз үсэгтэй ажээ.

Я.Ганбаатар

Бээжин хотын баруун өмнө дүүрэгт Бай юньгуань буюу Цагаан үүлийн сүм хэмээх бомбын шашны их сүм буй. Мянганыг элээн өнөөг хүрч ирсэн энэ сүмийг Чингис хаан Чанчунь бомбод соёрхон шагнаж, насан туршдаа энэ сүмийг эзэгнэн эрхшээн суутугай хэмээн айлдан зарлигласан байдаг. Тэр ёсоор Чанчунь бомбо тэнгэрт хальтлаа энд сууж, нийт Хятад орны бомбын шашны бүхий л үйл хэргийг эрхлэн шийтгэж байжээ. Түүнийг 1227 оны зун тэнгэрт халихад нь Чингис хаанд дуулгасанд хаан бээр уг сүмийн түний тахилын сүм болгохыг зарлигдсан бөгөөд Чингис хааныг тэнгэрт хальсны удаахь хоёр онд Их Монгол Улсын төрийг барьсан отгон хүү Тулуйн зарлигаар энд Чанчунь бомбын тахилгын дуганг нэмж барьсан нь өнөө ч сүндэрлэн буй.

Бас эндэхийн музейд хятад хэлээр бичсэн Чингис хааны зарлигийн захидлын хуулбар хувь хадгалаастай байдгийн дээр, сүмийн архивт 1720-иод оны сүүлчээр хятад хэлнээс монголчлон орчуулж, худам үсгээр бичсэн хувь хадгалагдаж байгааг миний бие 2007 онд сүмийн мэдэлтнүүдтэй хэдэнтээ уулзахдаа завшаанаар олж үзсэн юм. Манж дайчин улсын Найралт төв хааны үед буюу аргын 1720-иод оны сүүлчээр өвөрлөгч монгол хошууны нэгэн ноён эл захидлыг олж үзээд монголчлон буулгаж хадгалуулсан эх хувь байсан шиг санагдана. Хожим дахин үзэх завшаан олдох биз ээ.

Би эл зарлигийн захидлаас хувь хуулбар авч, Монгол Улсдаа залахсан гэсэн хүслээ сонин хэвлэлээр ард иргэд, төр засагт илэрхийлж ирсэн. Энэ мянган гарснаас хойш Монгол Улсын гуравдагч Ерөнхийлөгч Н.Энхбаяр, өнөөгийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нар Франц, ОХУ, Итали, Вагикан зэрэг улс оронд төрийн айлчлал хийх үеэрээ тухайн улсын музей, номын санд хадгалагдаж байдаг Монголын түүх, соёлд холбогдох өв дурсгалуудаас хувь хуулбар авч уугуул эх оронд нь залах буянтай сайхан үйл хийсээр байна. Сүүлийн үед ШУА, Нүүдлийн соёл иргэншлийг судлах Олон улсын хүрээлэн зэрэг байгууллага Чингис хаанаас Чанчунь бомбод илгээсэн эл заллагын захидлаас хувь хуулбар авч эх орондоо залах талаар хөөцөлдөж байгаад талархаж байнам.

Бид энэ түүхэн том үйл явдлыг олон талаас нь ултай судлах шаардлага тавигдсаар байна. Тухайлбал Чанчунь бомбын сургаал айлдлыг улс төр, цэргийн хэрэг, дайн энх, олон улс гадаад харилцаа, шашин номлолын талаас нь судлах нь сонирхолтой төдийгүй чухал ач холбогдолтой байхын дээр, Чингис хаанаас түүнд алтан гэрэгэ соёрхон шагнасан, “Бомбын ёсны их хутагт арш” хэмээх цол хүртээсэн, Тэнгэрийн доорхи орны бүх бомбын шашны тэргүүнээр тохоон өргөмжилсөн тухай, энэхүү Цагаан үүлийн сүмийн түүх цадиг зэргийг ч нарийвчлан судлах нь түүхийн үл мэдэгдэх олон үйл явдлыг сэргээн бичихэд ихээхэн хувь нэмэр болох нь дамжиггүй.

Энд би ганцхан жишээ эш татан дурдая: Уг захидалд буй “...Би бээр өмнө зүгийн Сүн төр улстай холбоо тогтоож, өрнө зүгийн Сартуул улстай хаяа нийлэх болсон агаад Зүүн Ся улс зэрэг харь этгээдийн олон улс орон надад харьяат түшмэл улс болон дагаад байнам. Сэтгэхүл энэ нь манай Шаньюйн улсад мянган он, зуун үед эс гарсан хэрэг болвой...” гэсэн их хааны энэ үгээс бид монголчуудын угсаа гарлын тухай маш чухал тодорхойлолтыг олж харах болно. “Манай шаньюйн улс” гэсэн энэ үгээрээ Чингис хаан, бид бол эртний агуу их нүүдэлчин угсаатан Хүн нарын удам хойчис мөн гэж батлан илэрхийлжээ. Моодун шаньюйн байгуулсан Хүн гүрнээс хоёр мянганы хойнох өнөөгийн бидэнтэй харьцуулахад тэднээс мянган жилийн хойно, биднээс мянган жилийн өмнө аж төрж асан Чингис хааны монголчууд удам судраа илүү тодорхой мэддэг, цагийн зааг ялгалын хувьд илүү ойр дөт байсан нь гарцаагүй ээ.

Я.Ганбаатар

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

- Ш.Бира “Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа” Улаанбаатар, 2001
Я.Ганбаатар “Нангиадын сонгодог утга соёлын товчоон” Улаанбаатар, 2006 он
Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг, Д.Наран, А.Пунсаг “Монголын Юань улс” Улаанбаатар, 2006 он
Ч.Далай “Их Монгол Улс 1206-1260 он” Улаанбаатар, 1994 он
Мансан “Монгол үндэстний бүрэн түүх” 6 боть, Мүгдэн хот, 2004 он.
Г.Сүхбаатар “Монголын эртний түүх судлал” Улаанбаатар, 2005 он
Ли Жичан “Чанчунь бомбын баруунш зорчсон тэмдэглэл” Хөх хот, 2003 он, монголчилсон
Хүчэгэн
Ли Жичан “Чанчунь бомбын баруунш зорчсон тэмдэглэл” Хөх хот, 1993 он, монголчилсон
Дэжүүр
Ли Жичан “Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” Улаанбаатар хот, 2010 он,
орчуулсан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар
Д.Наран “Монголын төрт ёсны боловсролын түүх” Улаанбаатар, 2001 он
Чойжи “Монголын Бурхны шашны түүх: Юань улсын үе” Хөх хот, 2001 он
“Юань улсын судар дахь Чанчунь бомбын намтар” МУИС НШУС-ийн ЭШБ, Түүх,
Улаанбаатар, 2009 он, Ц.Ганбаатар, П.Дэлгэржаргал

Хятад хэлээр

- Ли Жичан “Чанчунь бомбын баруунш зорчсон тэмдэглэл” Хөх хот, 1997 он
Жоу Гаодэ “Бомбын ёсны Үнэн төгөлдөр шашны их хүрээлэн – Бай юнь гуань” Бээжин хот,
1999 он
“Бай юнь гуань – Цагаан үүлийн сүмийн танилцуулга” Бээжин хот, 2008 он
“Бомбын шашны Төгөлдөр үнэн ёсны таван өтгөс, долоон аршийн хэрэг явдал – Алтан улс,
Юань улсын үеийн бичмэл эх сурвалжууд” Бээжин, 1990 он
Жу Инь “Юань төрт улс” Бээжин, 2005 он
Лун Шу, Лю Дэ У нар “Юань төрт улс” Чанчунь хот, 2006 он.
Ман Чан “Монгол үндэстний бүрэн түүх” 4 боть, Шэньян, 2004 он
Сян Инь зье “Төв Ази: Морин дэл дээрх соёл” Тайбэй, 1996
“Лаоз мэргэний номлосон сургаал - Тайшань гань ибэн” Бээжин, Цагаан үүлийн сүмийн
хэвлэх үйлдвэр, 2006 он

ON THE STUDY OF THE CHINGGIS KHAN'S LETTER OF INVITATION TO MASTER QIU, A DAOIST MONK OF CHINA

In this article author touched the historical event concerned to meeting of Chingis khan, the founder of the Great Mongol Empire of XIII-th century, to Qiu Chanchun, the founder of the Longmen sub-sect under the Quanzhen sect of China. Situated in the West City District, Beijing, the White Cloud Daoist Temple is the largest and the only one of its kind open to the public. Emperor Chingis Khan ordered the temple rebuilt and invited Qiu Chanchun, to live there in 1224, after back to his nativelyland China.

In the museum of the temple, there is Chingis Khan's letter of invitation. Dated 15 May 1219, has been preserved, one of the great curiosities of history. Qiu Chuji, or Changchun Zhenren in Chinese, Master Qiu or Daoist Monk and Alchemist Qiu in English, was born 1148, in Shandong, China, died 1227, in Beijing. He travelled from China through central Asia to Persia, or today's Afghanistan.

It took them two years to arrive in the snowy mountains of Afghanistan, covering a distance of over 5000 kilometers. When he finally met with Chingis khan he tried to dissuade the latter from killing, meanwhile, he preached Daoist doctrine to Chingis khan, advising him to revere the heaven and love his people on the one hand, and have a pure heart and few desires on the other hand. For this reason, he was conferred the title of Shenxian, or Immortal in English, and Taizongshi, or Great master in English, by Chingis khan. Such he traveled more than 10 thousand miles to meet Chingis khan in order to convince him to follow the Daoist principle of stop killing.


Qiu Chanchun died in 1227 and Chingis Khan renamed the temple Chanchun Palace in his memory. Qiu's remains are buried beneath the bowl, into which the faithful still offer money. Built in the Yuan Dynasty on the order of Prince Tului, youngest son of Chingis Khan, who ruled temporarily the Great Mongol State. Inside the hall, Qiu's statue is enshrined.

His disciple Li Zhichang chronicled Qiu's journey to meet Chingis khan. Such the book named "Travels to the West Qiu Chanchun" was published by another disciple Sun Xi, with a preface dated 1228. But was forgotten for more than five hundred years, until 1795 Qing dynasty scholars rediscovered this work and distributed it. Author of this article in 2010 translated this book into Mongolian.

Я.Ганбаатар



1. Бумбын шашны их арш Чанчунь



2. Чанчунь бомбыг урсан Чингис хааны захидлыг сийлсэн хөшөө




3. Чанчунь бомбын Цагаан үүлийн сүмийн их хаалга



4. Чанчунь бомбын шуумал баримал




5. Чанчунь бомбыг чандарлан оршоосон тахилын бумба



6. Чанчунь бомбын аяллын зураг



7. Чанчунь бомбын аяллыг үзүүлсэн дэлгэмэл зураг



8. Чанчунь бомба Чингис хаанд бараалхан сургаал айлдаж байгаа нь